

**ТАЙЛАНД ОРНОО СЭРГЭЭН  
МАНДУУЛСАН ВАН**

Тайландын ван дэлхий дээр хаан ширээнд хамгийн удаан сууснаараа, бас улс орныхоо эдийн засгийг гайхалтай хөгжүүлснээрээ хамгийн их алдаршсан хүн юм. Сүүлийн 20 жилд жил бүр дунджаар 3,7 % өссөн, 1988, 1989 онуудад 11 орчим хувиар өссөн нь дэлхийд толгой цохисон үзүүлэлт юм. Одоо Тайландын 1 хүний дундаж орлого 1000 америк долларт хүрчээ. Ийм ч учраас Тайландыг «Азийн тав дахь жижиг луу» болно хэмээн хүмүүс үздэг.

Тайландын Ван Пумипон Адудьядет болон Засгийн газар үндэсний эдийн засгийн хөгжлийг чухалчлахдаа улс төрийн тогтвортой байдал, түүний урьдач нөхцөл болох улсынхаа нөхцөл байдал дэлхийн чиг хандлагыг зөв зохицуулсан хөгжлийн стратегийг цаг тухайд боловсруулахыг эрхэмлэдэг.

Тайландын хүн ард түүнийг улсын түүхэнд хүндтэй гавьяа байгуулсан, эрин үеийн нэртэй зүтгэлтэн «улсаа мандуулсан ван» хэмээн дээдлэн өргөмжилдөг.

**Хүмүүжил, боловсрол**

Пумипон 1927 оны 12-р сарын 5-нд АНУ-ын Массачусетс муж улсын нэгэн хотод төрсөн. Эцэг Масипутан Бангкокийн вант улсын ван Жулалун гүний отгон хүү, хожим «Тайландын орчин үеийн анагаах ухааны эцэг» болсон билээ. Эх Шинакалин жирийн айлын охин бөгөөд 16 настайдаа АНУ-д очиж суралцахдаа Масипутантай танилцаж, 1920 оны 9-р сард гэрлэжээ.

Пумипоныг мэндлэх үед Тайландын вант улсад өөрчлөлт гарах дөхөөд, ордны гадна доторгүй үймээн самуун өрнөж, тэрбээр хүний анхаарлыг нэг их татсангүй. 1935 оны 3-р сард Бангкокийн вант улсын VII Рама-г цэргийнхэн эргэлт хийн түлхэн унагаж дөнгөж 10 настай Пумипоны ах Ананд хаан ширээнд сууж VIII Рама болов. 1946 онд тэрбээр албан ёсоор хаан ширээнд суусны дараахан гэнэт гэртээ нас баржээ. Тэгэхэд ордны том түшмэд 19 настай Пумипоноос хаан ширээг залгамжлан авахыг хүсч байгаагаа илэрхийлэхэд тэрбээр зөвшөөрч IX Рама болжээ.

Ван Пумипоныг эх нь нялх багаас залж чиглүүлж, аливаа хүн өөрийгөө хянаж чадваас ямар ч зовлон бэрхшээлийг үл ажран, эцсийн эцэст санасандаа хүрч чадна хэмээн сургадаг байлаа. Мөн түүнчлэн хүүдээ «шинэ жил болон төрсөн өдрөөс бусад тохиолдолд бусдын өгсөн бэлэг сэлтийг» авдаггүй өрх гэрийн ёс журмыг захиж өгчээ. Энэ мэтээр эхийн сургамжийн үг, үлгэр дууриал Пумипоны амьдрал хувь заяанд асар их нөлөөлсөн билээ.

Пумипон Бангкокт бага сургууль дүүргээд Швейцарын Лозанн хотноо дунд сургуульд сурсны дараа уг хотын их сургуульд нь элсэн оржээ, 1950 онд хаан ширээнд албан ёсоор суусны дараа дахин уг их сургуульд ирж улс төр, хууль зүйд шамдан суралцсан байна.

**Ван үүрэг хариуцлагаа ухамсарласан нь**

Пумипон ван жил бүр 8 сарын хугацаанд Тайландын өнцөг булан тийш аялдаг учир түүнийг «хамгийн уйгагүй хүн» гэж нэрлэжээ. 20 гаруй жилд тэрбээр 71 мужийн 620 гаруй хотуудаар орж, Тайландын зүүн хойд талын ядуу тосгодоор орсон анхны ван болсон байна. Гай гамшиг учирсан газарт Пумипон өөрийн биеэр очоод зогсохгүй ядуу

тариачин өрхийн аж байдалтай танилцдаг бөгөөд тариачин олонд тохиолдсон зовлон гачиг, эрэлт хэрэгцээг тэмдэглэн авч 50 хүнтэй зөвлөл байгуулан уг асуудлыг шийдвэрлүүлдэг. Хожим ямар үр дүнтэй болсныг лавладаг.

Ванг улс орноор аялан явахад хатан нь ямагт цуг байж өвчин эмгэгт нэрвэгдсэн хүмүүсийг эмчлэн, эм тан түгээдэг байна. Гай гамшиг тохиолдсон нутагт тэр өөрийн биеэр хэрэгтэй эд зүйлийг хүргэн өгч байлаа. Энэ эмэгтэй вангийн хатан боловч даавуун хувцас өмсөн эгэл олны нэгэн адил тэдний баяр зовлонг хуваалцаж буйгаа харуулдаг ажээ.

1932 онд Тайландад тайван замаар төр солиглож Үндсэн хуульт хаант засаг тогтов. Гэхдээ ван хэмжээлшгүй эрх мэдэл, эдлэн газар, эд хөрөнгө эзэмшиж байлаа. Пумипон улсын ван болсны дараа нэг хэсэг хугацаанд улсын эдийн засаг, ард түмний аж байдлыг нэг их сонирхолгүй, ордны тансаг амьдралд умбаж байв. Хожим гамшигт нэрвэгдсэн нутгаар явахдаа нутгийн иргэдийн уранхай ноорхой хувцас, хүнд амьдралыг үзээд ихэд цочирдон, төрийн жолоог барьсан хүний үүрэг, хувь заяаг ухаарч ордны амар жимэр амьдралаа орхиж Тайландыг хөгжүүлэн бадруулах үйл хэрэгт хүч чадлаа зориулахаар шийджээ.

Тэрбээр алт эрдэнэсээр гоёж чимэглэсэн гангийн их ордноо жирийн иргэд, зочид жуулчдад сонирхуулахаар байнга нээлттэй болгон, өөрөө тусдаа ордон барьж аж төрөхөөр эгнэгт шийдэв. Энгийн тавилгатай энэ ордны дотор цагаан будаа тарин, мод үржүүлэх талбай болон саалийн үнээ, загасны аж ахуйн ферм бүхий хөдөө аж ахуйн жижиг тосгоныг өөрийн биеэр байгуулсан байна. Пумипон 3—4 насандаа мод, зүлэг услах, ой модонд маш их дуртай байсан бөгөөд улсын ван болсны дараа өөрөө гардаж туршилт хийж, хөдөө аж ахуйн шинэ бүтээлийн газар нээн эрдэмтэдтэй зөвлөлдөж хөгжлийн программ боловсруулжээ. Гамшигт нэрвэгдсэн нутаг, хөдөө тосгодоор явахдаа ван тариачдад орчин үеийн хөдөө аж ахуйн тухай таниулга хийх, моторт худаг угсрах, услалтын суваг татан үрийн сортыг хэрхэн сонгох, нутгийн жижиг үйлдвэр яаж байгуулах талаар заавар зөвлөлгөө өгдөг байв. Тэрбээр хамаг сэтгэл зүрх, хүч чадлаа улс орныхоо мандан цэцэглэлт, ард түмний сайн сайхан амьдралд зориулсан тул Тайландын ард түмэн «улсаа мандуулсан ван» хэмээн хүндэтгэдэг.

### **Хүчтэй ерөнхий сайд нар**

Пумипон вангийн нөлөө, санаачлагаар тус орны ерөнхий сайдаас энгийн албан хаагч хүртэл бүгд нөр хичээнгүй хөдөлмөрлөх болж, улмаар ажил амьдралын нь хэвшил болжээ. Сүүлийн 10 гаруй жилд засгийн газрыг толгойлсон 3 ерөнхий сайд тус улсын эдийн засгийн хөгжилд маш чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

60-аад онд Тайландын эдийн засгийн хөгжил хэр тааруу байв. 70 оны дунд үед ерөнхий сайдын орлогч байсан Сити-Савесила ерөнхий сайд болохдоо хэдийгээр нас 70 гарсан боловч бие сэтгэлээрээ хүчтэй, идэвхитэй байхын зэрэгцээ залуу нөхдийнхөө сэтгэл санааг урамшуулан шаргуу хөдөлмөрлөж байв. Цаг тухайд зүй зохистой арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тайландын эдийн засагт нааштай өөрчлөлт гарсан билээ. 80-аад оны эхээр Прем Тинсуланоныг ерөнхий сайд болох үед ядуурал, ажилгүйдэл, өр зээл гэсэн гурван том асуудал тулгарчээ. Засаг төрөөс хөдөө аж ахуйг идэвхтэй дэмжиж, 5 жилд хөдөө тосгоныг хөгжүүлэхэд 54 тэрбум бат (2,16 тэрбум америк доллар) хөрөнгө гар-

гаж, соёл боловсрол, нийтийн аж ахуй эрчимтэй хөгжсөнөөр тариачдын орлого нэмэгдэж ажилгүйдэл, өр зээл аажмаар багасч ирэв. 1987 онд Тайландын эдийн засгийн хөгжил 7%-д хүрч Зүүн өмнөд Азийн орнуудын тэргүүн эгнээнд гарч тэр үеэс сэргэн мандлын шинэ шатанд шилжин орсон билээ.

1988 онд Чатчай Чунхаван ерөнхий сайдын албан үүргийг 66 насандаа хүлээж авсан. Тэрбээр бага залуудаа хангалуун амьдралд умбасан тул язгууртан зан байдал буюу бүжиг, архи, тамхи, гольф, теннис тоглох дуртай байв. Гэвч ерөнхий сайд болсны дараа тэр сурвалжлагчид ярихдаа, хойшид өөрийг нь «эрх танхи амьтан» гэж хэлэхгүй байхыг хүсээд, «би ийм байдлаар амьдардгаа дуусгавар болгож, улс нийгмийнхээ төлөө цуцалтгүй хөдөлмөрлөнө» гэжээ. Үнэхээр ч энэ үг хоосон зүйл биш байсан бөгөөд тэрбээр улс төрд гялалзсан амжилт олсны зэрэгцээ эдийн засгийг хөгжүүлэх талаар гүнзгий мэдлэг эзэмшсэн нь өөрийн танхимаа эмхлэн байгуулсны дараа зах зээлийг тогтворжуулан, эдийн засгийг ахиулахад их тус дөхөм болсон юм. Тэгээд ч Чунхаван Тайландын эдийн засгийг цэцэглүүлэхийн төлөө цуцалтгүй хичээн зүтгэсэн билээ.

Бас нэг тэмдэглүүштэй зүтгэлтэн бол Бангкок хотын дарга Жанлон юм. Эдүгээ 54 настай энэ хүн чөлөөнд гарсан генерал, хатуу чанга сахилга батаар нэрд гарчээ. Бангкок хотыг цэгцлэн журамлахын тулд ялзарсан аливаа байдлыг үндсээр нь арилгахыг чармайн, «бага идэж, цөөн мөнгө зарж, их ажилла» гэсэн уриа дэвшүүлжээ. 10 гаруй жилд тэрбээр цагаан хоол идэж, тариачны хувцас өмсч, шөнө вандан дээр унтаж байлаа. Өөрийн сарын цалин 1352 долларыг буяны үйлсэд хандивлаад, цэргийн тэтгэврээр энгийн амьдарч байв.

Бангкок 5,6 сая хүнтэй бөгөөд урьд зам харилцаа муу, агаар бохир, янхны газар дүүрэн, ядуус өдөр ирэх тутам нэмэгдэж, түшмэд нь ялзран доройтсон байлаа. Эдгээр хүнд бэрх асуудал Жанлонд тулгарсан боловч удаа дараа янз бүрийн арга хэмжээ уйгагүй хэрэгжүүлсний дүнд аажмаар байдал сайжирчээ. Улам бүр хүндэрч байсан зам тээврийн бэрхшээлийг гэтэлгэх үүднээс их хурдтай хангай зам, өндөрт байрлалтай цахилгаан тэрэг нэвтрүүлэх төлөвлөгөө идэвхийлэн гаргаж, хотын ариун цэвэр эрүүл ахуйн байдлыг сайжруулах бүх нийтийг хамарсан компани ажлыг төлөвлөсөн хугацаанд явуулдаг болжээ. Хотын дарга захиргааны ажилтнуудаа хотын амьдралд орж байхыг шаардахын хамт өөрөө энгийн иргэдийн зовлон зүдгүүрийг хуваалцан боломжтой үед тэр даруй эрс шуурхай арга хэмжээ авч, бага хүч зарж их амжилт олохыг эрмэлздэг. Жанлоний энэ бүх хүчин чармайлт тодорхой үр ашгаа өгч Тайландын эдийн засгийг дэвжээхэд хувь хандив оруулсан чухал зүтгэлтэн болжээ.

### **Тогтвортой байдлын билэг тэмдэг**

Пумипон ван улс даяар маш их нэр хүндтэй, тус орны тогтвортой байдалд нэн чухал үүрэгтэй.

Ван төрийн эрхийг залгамжлан авах үед цэргийн эрхтнүүд засгийн эрх мэдлийг эзэгнэж байсны улмаас үйл ажил явуулахад түүнд бэрх байв. 1957 оноос улс орон цэргийнхний дарангуйллаас аажмаар гарах тутам, ялангуяа 70-аад оны үеэс Пумипон засаг төрийн ажлыг гартаа оруулж, түүний үүрэг нөлөө нь улам бүр мэдрэгдэх болжээ. 1981 онд цөөн тооны цэргийн хүн төрийн эргэлт хийж ерөнхий сайд Прем Тинсуланоныг баривчилсан тухай сонсоод ван түүнтэй уулзах хүсэлтэй байгаагаа илэрхийлж, нэн даруй суллахыг шаарджээ. Прем Тинсуланон суллагдмагцаа Вангийн хамт үймээнийг намжаан, эргэлт хийх гэсэн оролдлогыг дарсан ажээ. 1985 онд нийгмийн донсолгоо дахин гарч

төрийн эргэлт гаргахад Ван ерөнхий сайдаа илт дэмжсэн нь эргэлт гаргасан цэргийнхний дотор хагарал гаргахад хүргэж зарим удирдах офицерууд эргэлтийг эрс зэмлэн буруушаав. Эргэлт гаргагчид арга буюу вангийн саналыг дагахаас аргагүй болж, улс төрийн байдал тогтворжиж ирэв.

Тайландын эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэхэд шаардлагатай нийгмийн тогтвортой байдлыг хангах үүднээс Пумипон ван засгийн газрын яамдад удаа дараа хээл хахуулийн эсрэг арга хэмжээ авч явуулав. П. Тинсуланон хэд хэдэн сайд, том түшмэдийг албан тушаалаас нь зайлуулсан нь өргөн олны талархлыг хүлээж «цэвэрлэн ариутгагч ноён» гэсэн нэртэй болжээ. Тэгээд ч хээл хахуулд автаж ялзарсан этгээдийг цэвэрлэн зайлуулах, түүнээс урьдчилан сэргийлэх ажил эдүгээ Тайландын засгийн газрын байнгын зүйл болсон ажээ.

Ван улсын боловсролыг хөгжүүлэхийг ихэд чухалчлан үздэг. 50 оны сүүлчээс 70-аад оны эхэн хүртэл Тайландаас олон тооны эмч, эрдэм шинжилгээ, техникийн ажилтнууд голчлон АНУ, Европын орнуудад очиж ажил мэргэжил, мөнгө хайн явах үзэгдэл газар авч тэдний 26 % тэндээ суурьшжээ. 80-аад оны үед төрөөс эрдэм мэдлэг, мэргэжилтнийг үнэлэн үзэж оюун ухаан урсан гаргахыг хязгаарласнаар гадаадаас буцаж ирэх явдал нэмэгдсэн байна. 1980 онд зөвхөн эмч гэхэд буцаж ирсэн нь гарч явснаас 3,5% илүү болжээ. Сүүлийн жилүүдэд Засгийн газраас сэхээтнүүдэд өндөр цалин, шан харамж өгөх бодлого явуулж тусгай мэргэжлийн хүмүүс өндөр шан хөлс бүхий хоёр дахь мэргэжлийн ажил хийж, Их сургуулийн багш нар судалгааны ажил хийхийг зөвшөөрч, мөн түүнчлэн хувийн сургууль байгуулах, гадаадад ажил хавсран хийх бололцоо олгосны зэрэгцээ орон сууцны хөлсийг бууруулсан байна.

Пумипон ван дунд болон доогуур орлоготой өрхийн орон сууцны асуудалд онцгой анхаардаг. Тайландын засгийн газар 1973 онд тусгай алба байгуулан дунд, доогуур орлоготой өрхийн хүн ам, орон сууцны байдалд жилд 1 удаа тооллого хийж, барилгын төлөвлөгөө урьдчилан гаргадаг байна. Шинээр барьсан сууцны түрээсийн хөлс түрээслэгчийн цалингийн 20% байх бөгөөд байшин худалдаж авбал зээлийг 20 жилээр хуваан төлдөг ажээ. Тайланд ихээхэн хүч зарж хотын ядуучуудын хорооллыг өөрчилж чадсанаар олон түмний ахуй нөхцөлийг эрс сайжруулжээ. Дээр дурьдсан арга хэмжээний үрээр Тайландын хүн амын зонхилох хэсэг болох дунд, доод давхарга ван болон засгийн газарт гүнээ итгэж хүндэтгэл үзүүлж, шаргуу хөдөлмөрлөх болсон нь улс орон тогтвортой, өрнүүн хөгжих уур амьсгал бүрдүүлжээ.

#### **Олон талын авьяас чадвартай хүн**

Пумипон ван тал бүрийн авьяас чадвартай хүн бөгөөд гадаадын 7 хэл сайн мэддэг, хүсэж сонирхдог зүйл маш өргөн, ард олныхоо дунд ч их нэр хүндтэй.

Тэрбээр гэрэл зураг авах их дуртай. Энгийн үедээ хатнаа гол объект болгон авах, хөдөө нутагт ажлаар явахдаа тосгон, уулархаг бүсийн байгалийн үзэмж, жирийн амьдрал харуулсан зураг дуртайяа авдаг байна. Тэр бас хөгжимд дуртай, нот сайн мэддэг, 8 төрлийн хөгжим тоглож чаддаг. Нийт 44 хөгжим зохиосны дотор «Бороон торго» Тайландын хөгжмийн түүхэнд нэртэй бүтээл болсныг нийтээр хүлээн зөвшөөрчээ. 1980 онд ЮНЕСКО-гийн Азийн соёлын төвөөс гарсан «Ази, Номхон далайн дуу»-нд түүний энэ бүтээлийг сонгон оруулжээ. 1964 онд Пумипоны хөгжимд гаргасан амжилтыг үнэлэн Венийн хөгжмийн академиас түүнд «Хүндэт академч» цол олгож, ийм цол хүртсэн Азийн анхны хүн болсон юм.

Тэр бас зураг зурах дуртай, ялангуяа хийсвэрлэх аргаар хүний янз бүрийн төрх байдлыг гаргахдаа тун чадмаг. Түүний зурсан зургийн өнгө хурц тод, хүний таашаал өөрийн эрхгүй татдаг. Ван үе үе өөрийн дүрслэх урлагийн бүтээлийн үзэсгэлэн гаргадаг байна.

Пумипон бол биеийн тамирын арга хэмжээг тууштай дэмжигч, өөрөө ч биеийн тамираар идэвхитэй хичээллэдэг. Урьд Швейцарт байхдаа машины уралдаан, далбаат завь, өдөн бөмбөг шимтэн сонирхдог байлаа. 1966 онд тэрбээр далбаат онгоц жолоодон Тайландын буланг 18 цагт туулжээ. 1987 онд Олон улсын олимпын хороо үүнийг үнэлж хамгийн хүндтэй одонгоороо шагнажээ.

Вангийн идэвхи санаачлагаар бухны мөргөлдөөн, заан сургах, загас зодолдуулах, могойгоор наадах зэрэг Тайландын үндэсний уламжлалт наадам сэргэн хөгжиж цаасан луу хөөргөх, усанд дэнлүү тавих ёслол, үр суулгасны баяр зэрэг ардын зан үйл өрнөн дэлгэрэх болжээ. Энэ мэт баяр наадам, зан үйл нь цэцэглэн хөгжиж буй Тайланд орныг улам өнгө жавхаалаг болгож байна.

Хятадын «Рен Ү» сэтгүүлээс орчуулсан **Д. Шүрхүү**

### **ИНДОНЕЗИЙН «РОКФЕЛЛЕР»- ЛИНЬ ШАОЛЯН**

Линь Шаолян, энэ нэгэн нэр Индонез төдийгүй Зүүн өмнөд Ази, бусад орнуудын үйлдвэр-худалдааныхны дунд аль хэдийн танил дотно болжээ. Гэвч 40-өөд жилийн тэртээ жирийн жижиг худалдаачин байсан хүн дэлхийн 6 дахь том баян болсны нууцыг хүмүүс мэдэхийг ихэд хичээдэг гэнэ. Индонезийн 1-р баян Линь Шаоляны бүх хөрөнгө Америкийн Рокфеллерийнхийг давж 7 тэрбум ам. долларт хүрчээ. Энэ хүний мэдэлд хэд хэдэн банк, мод боловсруулах үйлдвэр, уурхай, электроник, автомашин, усан онгоц, зочид буудал, даатгал, газар тариалангийн, зам тээврийн гэх мэт 192 пүүс, үйлдвэрийн газар бий. Мөн 60-аад оны үед үйл ажиллагаагаа эхэлсэн Азийн төв банк, 70-аад оны эхээр Сингапурт байгуулагдсан Хуажэньи банк бас Линь Шаолянтай холбоотой бөгөөд эдийн засгийн янз бүрийн салбарыг санхүүгийн талаар дэмждэг юм. Гадаад орнуудад хөрөнгө оруулалтаар хэд хэдэн үйлдвэрийн газар байгуулсан байна. Үүнээс гадна АНУ-ын Калифорни муж улсын нэгэн банк, Америкийн Хуатун банкиг эзэмших эрхийг тус тус олж авсан нь АНУ дахь түүний байр суурийг бэхжүүлжээ.

1975 онд ашиглалтанд орсон цементийн үйлдвэр жилдээ 10 сая тонн бүтээгдэхүүн гаргадаг. Үүний ачаар Индонез улс цементийг урьд өмнө гадаадаас авдгаа больж экспортоор гаргадаг болсон байна. Энэ бол Линийхний хамгийн том үйлдвэрийн газар бөгөөд түүнтэй зэрэгцэх ижил том үйлдвэр өөр аль ч оронд үгүй ажээ.

Индонезийн төмөрлөгийн үйлдвэрийг байгуулахад зарцуулсан хөрөнгийн 40%-ийг Линь Шаолян гаргасан. Уг үйлдвэрийн хөрөнгө оруулалтанд оролцохоор шийдэхэд нь бусад хүмүүс «ийм их зардал шаардсан дэмий юманд мөнгөө урсгах хэрэг юун» гэж эргэлзэж байжээ. Гэтэл төмөрлөгийн үйлдвэр ажиллаж эхэлсний дараахан Линий шийдвэр зөв болох нь харагдсан. юм. Индонезийн өмнө өөрийн хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх ирээдүй ингэж нээгдэв. Линь Шаоляныг хүмүүс «Индонезийн Рокфеллер» хэмээн энэ цагаас нэрлэх болжээ.